



**НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

┌ Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах ┐  
└ дэд хөтөлбөр батлах тухай ┘

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:


1. Дүүргийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, иргэд, олон нийтийн хэвшмэл хандлагыг өөрчлөх, хүний нөөцийг чадавхжуулах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хамтын амьдралыг дэмжих зорилтын хүрээнд “Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар ханган, биелэлт үр дүнг бүтэн жилээр дүгнэж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнаж ажиллахыг Засаг дарга Ч.Раднаабазарт үүрэг болгосугай.

ДАРГА  Б.НЭРГҮЙ

1176100072

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 06 дугаар  
сарын 09-ний өдрийн 25 дугаар тогтоолын  
хавсралт



## НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР (2020-2025 он)

### НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР

**Жендэр:** Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлага

**Жендэрийн эрх тэгш байдал:** Эмэгтэй, эрэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх Жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах /Gender mainstreaming/: амьдралын бүхий л хүрээнд жендэрийн үзэл баримтлалыг тусгах үйл явц ба стратеги. Аливаа бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны, түүний дотор хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн эмэгтэй, эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд ялгаатай нөлөөлөх байдлыг анхаарч тооцох, тэдний ялгаатай хэрэгцээг болон мэдлэг туршлагыг эн тэнцүү үнэлж, анхаарах үйл явц, стратеги.

**Жендэрийн мэдрэмжтэй байдал:** Эрэгтэй, эмэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, мөн хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлсийг анхаарч тооцох хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадвар.

**Жендэрийн хэвшмэл үзэл:** Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлага.

**Жендэрийн статистик:** Жендэрийн тулгамдаж буй асуудал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж өөрчлөхөд чиглэсэн бодлого боловсруулах үйл явц ба дүн шинжилгээ хийхэд шаардагдах хүйсээр ангилсан тоон мэдээлэл.

**Хүйсээр ангилсан тоон мэдээлэл:** Хүйсээр ангилсан тоон мэдээллийг цуглуулах, тайлагнах нь жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилтэд жендэрийн дүн шинжилгээ хийх анхан шатны алхам юм. Энэ нь жендэрийн тулгамдаж буй асуудал, тэгш бус байдлыг илрүүлэхээс гадна тухайн үйл явц нь бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж, салбарын эмэгтэйчүүд,

эрэгтэйчүүдийн оролцоо, байгууллагын үйл ажиллагаанд анализ хийхэд чухал ач холбогдолтой.

**Жендэрийн мэдрэмжтэй төсөв:** Нийгэмд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлого, төлөвлөлтийг дэмжсэн, түүнийг хэрэгжүүлэх төсөв, салбар, байгууллагын жендэрийн чадавхийг сайжруулахад зориулагдсан тусгайлсан төсөв, тодорхой бүлгийн ялгаатай хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагааны төсөв гэсэн хэлбэрүүдээр хэрэгжинэ.

**Ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрт байдал:** Эмэгтэй, эрэгтэй ажилтны гэр бүлдээ хүлээх үүрэг, хариуцлага, эмэгтэйчүүдийг албан тушаал дэвшихэд саад болж буй хүчин зүйлс, эсвэл бага цалин хөлстэй ажилд ороход хүргэж буй шалтгаан, эрэгтэйчүүдийн хувьд гэр бүлдээ оруулах хувь нэмэр, чадавхыг хязгаарлах, эрүүл мэндтэй холбоотой эрсдэлийг бий болгож буй хүчин зүйлсийг илрүүлэн бодлого төлөвлөлтөд харгалзан тусгах явдал. Энэхүү ажил-ар гэрийн амьдралын төлөвлөлт, тэнцвэрт байдлыг харгалзсан бодлого нь жендэрийн эрх тэгш байдлын суурь шаардлагын нэг юм.

**Тусгай арга хэмжээ:** Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш бус байдлыг арилгах, тэгш байдлыг тогтооход чиглэсэн зориудын арга хэмжээ. Ийм арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үздэггүй. Тэгш боломж, тэгш байдал тогтоох зорилго биелэгдмэгц тусгай арга хэмжээг зогсооно.

**Жендэрийн дүн шинжилгээ:** Бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа нь нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээнд суурилсан эсэх, оролцоо болон ашиг хүртэх тэгш боломжийг тэдэнд бий болгож байгаа эсэхийг үнэлэн судалж, анхааран тооцох үйл явц. Жендэрийн шинжилгээг хийхдээ хүйсээр ангилсан тоон мэдээллээс гадна бодлогын дүн шинжилгээ болон чанарын судалгааны арга зүйг хавсран ашиглана.

**Оролцоонд суурилсан жендэрийн аудит:** Жендэрийн үзэл баримтлалыг үйл ажиллагааны түвшинд нэвтрүүлэхэд хэрэглэх хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал. Энэ нь жендэрийн үзэл баримтлалыг бодлого, хөтөлбөр, бүтэц зохион байгуулалтдаа бодит үр дүнтэйгээр тусган хэрэгжүүлэх, энэ явцад байгууллагын хүрээнд суралцах үйл явцыг дэмжих, түүнийг байгууллага, салбар нэгж, ажилтны түвшинд үнэлэхэд чиглэдэг.

**Жендэрийн хяналтын хуудас:** Аливаа бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-үнэлгээний шатанд жендэрийн үзэл баримтлалыг үйл ажиллагаанд нэгтгэх үйл явцад хэрэглэх жендэрийн нөхцөл байдлыг шалгах асуулт, эсхүл үзүүлэлтийн жагсаалт.

**Жендэрийн үзүүлэлт:** Жендэрийн мэдрэмжтэй бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт. Энэ нь хувь хүний болон өрхийн түвшинд арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд гарсан дэвшлийг хэмжихэд түлхэц болно. Жендэрийн ялгаварлан гадуурхалт: улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм,

соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүй.

**Жендэрт суурилсан хүчирхийлэл:** Жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүй .

**Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл:** НҮБ-ын тодорхойлолтоор “бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл”-ийг өөрөөс сул дорой байдал, албан тушаал, эсхүл итгэлцлийг ашиглан бэлгийн сэдлээр ашиг хонжоо олох, нийгмийн эсхүл улс төрийн зорилгоор хийгдэж буй үйлдэл, эс үйлдэхүй” хэмээжээ. Энэхүү мөлжлөг, хүчирхийлэл нь ажлын байранд үйлдэгдэж болох бөгөөд түүнчлэн орон нутгийн иргэд өртөх магадлалтай, үүнийг аж ахуйн нэгж, байгууллагын хувьд эн тэргүүнд анхаарах шаардлагатай.

**Жендэрийн практик хэрэгцээ:** Энэ нь нөөц баялгийн хязгаарлагдмал хүртээмж, өдөр тутмын амьдралын нөхцөл байдалд илэрдэг эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг анхаарч тооцох, хангах явдал.

**Жендэрийн стратегийн хэрэгцээ:** Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гэр бүл, орон нутагтаа болон нийгэмдээ эзэлж буй ялгаатай байр суурьтай холбоотой бөгөөд эдгээрийг илрүүлж, тэгш байдлыг тогтооход чиглэсэн өргөн хүрээтэй бодлого, төлөвлөлтийг боловсруулж хэрэгжүүлэх нь чухал юм

**Ёс зүйн дүрэм:** Байгууллага, хувь хүмүүсийн түвшинд мөрдөх биеэ хэрхэн авч явах талаарх хэм хэмжээ, зарчмыг тусгасан акт.

## **Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Дүүргийн жендэрийн эрх тэгш байдлын дүн шинжилгээ”, “Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр боловсруулах удирдамж” зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгасан жендэрийн чиглэлээр төрийн албан хаагчид болон олон нийтийн хэвшмэл хандлагыг өөрчлөх, хүний нөөцийг чадавхижуулах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хамтын амьдралыг дэмжих, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлнэ.

Өнөө үед Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, эмэгтэй, эрэгтэй хүмүүс болон нийгмийн бүлгүүдэд хүрч буй төрийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэйгээр зорилтод бүлгийн хэрэгцээнд тулгуурлан хүргэхүйц, анхан шатны нэгжүүдийн ажилтан албан хаагчдын чадавхийг хөгжүүлэх жендэрийн нийцтэй үйлчилгээний орчинг бүрдүүлэх шаардлага үүсч байна.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүрэг байр суурийн талаарх жендэрийн хэвшмэл ойлголт тэгш бус байдал үүсгэж, нийгэм эдийн засгийн салбарт эн тэгш хөдөлмөрлөх тэдний эрхэлж буй ажил нийгэмд эн тэнцүү үнэлэгдэх боломжийг бүрдүүлэхэд жендэрийн асуудал зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болж байна.

Налайх дүүрэг нь хүн амын тоогоор Нийслэлийн 9 дүүрэг дунд 7 дугаар байрт жагсаж байгаа бөгөөд Засаг захиргааны нэгжийн хувьд 8 хороотойгоор иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна.

Налайх дүүрэгт 2019 оны жилийн эцсийн байдлаар 10295 өрхийн 3771 5 иргэн оршин байгаагаас 18669 (49,5%) нь эрэгтэйчүүд, 19046 (50.5 %) нь эмэгтэйчүүд, нэг өрхөд 3.5 хүн ногдож байна.

Дүүрэгт Монгол улсын нийт хүн амын 1.2 хувь, Нийслэл хотын хүн амын 2.6 хувь нь тус тус амьдарч байна. Налайх дүүргийн өрхийн тоо 2018 оноос 311 өрхөөр, 107 (2,8%) хүн амаар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 1582 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагийн 690 буюу 43,6 хувь нь эмэгтэйчүүд, 892 буюу 56,4 хувь эрэгтэйчүүд, 52,4 хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 147 буюу 9,3 % нь 0-14 насныхан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 828 буюу 52,3 хувь төрөлхийн байгаа бол 754 буюу 47,6 хувь нь олдмол байна

Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй, ажилгүй иргэдийн тоо 291, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 82 хүнээр (49.1%) өссөн ба 58.2 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна.

Бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 16.0 хувь нь 15-24 насны залуучууд, 38.1 хувь нь 25-34 насныхан, 27.3 хувь нь 35-44 насныхан, 14.4 хувь нь 45-54 насны, 4.0 хувь нь 55-59 насны, 2.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна.

Эдийн засгийн идэвхгүй хүн амд эзлэх эмэгтэйчүүдийн хувь хэмжээ 43.3% буюу 10, эдийн засгийн идэвхгүй хүн тутмын 4 нь эмэгтэй байгаа юм. Эдийн засгийн идэвхгүй байгаа шалтгааны нэгдүгээрт тэтгэвэрт, хоёрдугаарт суралцдаг, гуравдугаарт хүүхэд асарсан гэсэн шалтгаанууд тэргүүлж байгаа бөгөөд эмэгтэйчүүд хувьд хүүхэд асарч байгаа зэрэг хүчин зүйлүүд илүү нөлөөлж байна.

Иргэд, олон нийтийн дунд жендэрийн асуудал гэхээр эмэгтэйчүүдийн л асуудал гэсэн ойлголт байсаар байгаа тул бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх сургалт, гэгээрлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх шаардлага байсаар байна.

Хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, түүний дотор нөхөн үржихүйн насны залуу, бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийг ажилд авах сонирхолгүй байх, ахимаг насны эмэгтэйчүүдийг эрт тэтгэвэрт гаргах үзэгдлүүд түгээмэл байна.

Салбар бүрт хүйсээр ангилсан мэдээллийн сан, түүний ашиглалт жендэрийн дүн шинжилгээ хийх, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэхэд хангалтгүй байгаа тул жендэрийн статистик мэдээллийн нэр төрлийг нэмэгдүүлэх, салбар, дүүрэг, хорооны түвшинд ангилж гаргах хэрэгцээ байна.

Дүүргийн жендэрийн эрх тэгш байдлыг хангахад жендэрийн асуудлаарх шийдвэр гаргагчдын дэмжлэг, иргэд, олон нийтийн мэдлэг ойлголт дутмаг, уламжлалт ойлголт хандлага хэвээр, байгууллагуудын хамтын ажиллагаа сул, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт зэрэг бүхий л салбарт жендэрийн асуудал байсаар байгаа, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо бага, жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчийг хамгаалах асуудал

шийдэгдээгүй зэрэг байдлыг харгалзан орон нутгийн онцлогт тохирсон жендэрийн бодлоготой болох шаардлагатай хэмээн үзэж жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг боловсруулах хэрэгцээтэй байна.

## **Хоёр. БОДЛОГЫН ЗОРИЛГО**

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, Дүүргийн бодлогын зорилтод жендэрийн үзэл баримтлалыг тусгах, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлт хяналт шинжилгээ үнэлгээний арга зүйг нэвтрүүлж хэрэгжүүлэх, төрийн албан хаагчид болон олон нийтийн хэвшмэл хандлагыг өөрчлөх, хүний нөөцийг чадавхжуулах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хамтын амьдралын харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангахад оршино.

### **Гурав. Бодлогын зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагааны чиглэл**

3.1. Дүүргийн бодлого төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах, байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтан, албан хаагчдад жендэрийн талаарх эерэг ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлтийг бий болгох талаар сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах,

3.2. Иргэд, олон нийтэд эрэгтэй, эмэгтэй хүний эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд гүйцэтгэх үүрэг оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг явуулах, гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн хамтын үүрэг хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж хандлагыг өөрчлөх,

3.3. Иргэдийн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, орлогоо нэмэгдүүлэх боломжийг дээшлүүлэх, ногоон ажлын байр бий болгох төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх,

3.4. Иргэдийн гэр бүлийн тогтвортой байдал, нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт сурталчилгаа, тусгай арга хэмжээ авч ажиллах,

3.5. Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадавхжуулах, манлайллыг бий болгох чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.

### ***Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа***

3.1. Дүүргийн бодлого төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах, байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтан, албан хаагчдад жендэрийн талаарх эерэг ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлт, статистик мэдээллийн санг бүрдүүлэх талаар сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах,

3.1.1 Байгууллага, хороод гүйцэтгэлийн төлөвлөгөөнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар тусган, жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлтийг бий болгох,

3.1.2 Байгууллагын өдөр тутмын хөдөлмөрийн харилцаа ажиллах нөхцөлийг зохицуулсан эрх зүй бодлогын баримт бичгүүдэд жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан аливаа хүчирхийллээс сэргийлэх таслан зогсоох, гомдлыг шийдвэрлэх зохицуулалтыг тусгах,

3.1.3 Сургууль, цэцэрлэг, хороодын нийгмийн ажилтнуудад сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах, жендэрийн мэдрэмжтэй зөвлөх үйлчилгээний арга зүйг эзэмшүүлэх, баг бүрдүүлэх

3.1.4 Нутгийн удирдлагын болон нутгийн захиргааны байгууллагын бүх шатны удирдлагууд, төрийн албан хаагчдад зориулсан жендэрийн танхимын болон онлайн сургалтыг зохион байгуулах.

3.1.5 Жендэрийн чиглэлээр статистикийн мэдээллийн нэгдсэн сантай болох, хүйсээр ангилсан тоон тайлангийн хэрэглээг холбогдох байгууллага бүрт нэвтрүүлэх.

**3.2. Иргэд, олон нийтэд эрэгтэй эмэгтэй хүний эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд гүйцэтгэх үүрэг оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг явуулах, гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг эхийн хамтын үүрэг хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж хандлагыг өөрчлөх**

3.2.1 Жендэрийн чиглэлээр иргэдэд зориулсан гарын авлага, фото болон видео контентийг олон нийтэд түгээнэ.

3.2.2 Бусдыг хүндлэх, гэр бүлийн болон ойр дотны хүнээ хайрлан хамгаалах, хүнлэг чанарыг эрхэмлэх, эрүүл амьдралын зан үйлд суралцаж хорт буруу зуршлаас ангижрах арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааг насны онцлогт тохируулан үе шаттайгаар зохион байгуулах

3.2.3 Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг эхийн хамтын үүрэг хариуцлагыг таниулах чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлах,

3.2.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэн барилга байгууламж, зам талбайн орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн стандартыг хангуулна.

3.2.5 Хүүхэд, эмэгтэйчүүдийн түр хамгаалах төвийн үйл ажиллагааг тогтворжуулж, хамгааллын үйлчилгээг стандартын дагуу хүргэнэ.

3.2.6 Хэвтрийн болон байнгын асаргаа шаардлагатай өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эрүүл мэнд, халамж, банк болон боловсролын үйлчилгээг гэрээр хөнгөлөлттэй нөхцөлөөр үзүүлдэг тогтолцоог бий болгоно.

**3.3. Иргэдийн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, орлогоо нэмэгдүүлэх боломжийг дээшлүүлэх, ажлын байр бий болгох төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх**

3.3.1 Хөдөлмөр эрхлэлтийн төсөл, хөтөлбөрүүдэд зорилтот өрх болон нүүрсний уурхайд ажиллаж байгаа иргэдийг хамруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын байраар хангах

3.3.2 ЖДҮДТөвтэй хамтран ажиллах ажлын байр бий болгох 2-оос доошгүй төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

3.3.3 ЖДҮ эрхлэгчдийг жендэрт ээлтэй хөдөлмөрийн зохион байгуулалт, бизнес төлөвлөлтийн асуудлаар чадавхижуулах сургалт явуулах

**3.4 Иргэдийн гэр бүлийн тогтвортой байдал, нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж, тусгай арга хэмжээ авч ажиллах**

3.4.1 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх тасаг кабинет байгуулах, хүний нөөц техник тоног төхөөрөмжийн нөхцөл байдалд үнэлгээ хийх

3.4.2 Нөхөн үржихүйн насны охид хөвгүүдэд сургалт сурталчилгаа явуулж үзлэг шинжилгээ зохион байгуулах

3.4.3 БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх ээлтэй орчинг бүрдүүлж, иргэд, ялангуяа эрсдэлт бүлгийн иргэдийн дунд БЗДХ-ын илрүүлгийн ажлыг зохион байгуулах.

3.4.4 “Эрүүл налайхчууд” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэн ажиллах

3.4.5 Залуучуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах

3.4.6 Байгууллагуудад ариун цэврийн стандартын өрөөг байгуулах, сургууль бүрд охидын ариун цэврийн өрөөг бий болгох тэдэнд үйлчлүүлэх боломж нөхцлийг бүрдүүлэх

**3.5 Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадавхжуулах, манлайллыг бий болгох чиглэлээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.**

3.5.1 Дүүргийн хэмжээнд эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадавхжуулах, манлайллыг бий болгох чиглэлээр олон улсын болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах

#### **Дөрөв. Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа**

3.1.1 Эхний үе шат 2020-2023 он,

3.1.2 Сүүлийн үе шат 2024-2025 он

#### **Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр**

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр



5.1 Улсын болон орон нутгийн төсөв 5.2 Гадаад улс болон олон улсын байгууллагын хандив, буцалтгүй тусламж 5.3 Бусад эх үүсвэр 5.1 Улсын болон орон нутгийн төсөв

5.2 Гадаад улс болон олон улсын байгууллагын хандив, буцалтгүй тусламж  
5.3 Бусад эх үүсвэр

**Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн удирдлага,  
зохион байгуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээ**

6.1. Хөтөлбөрийн, үнэлгээ хяналт Жендэрийн салбар хороо удирдан зохион байгуулна.

6.2. Дүүргийн Засаг Даргын Тамгын газар нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, чанарын болон тоон үзүүлэлтийг ашиглан үр дүнгийн тайланг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан Жендэрийн салбар хороонд танилцуулна.

6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд гарч буй дэвшил, сорилт болон ил тод байдал, хариуцлагыг өндөржүүлэхийн тулд тайланг дүүргийн албан ёсны вэб хуудсаар олон нийтэд танилцуулах ажлыг дүүргийн Жендэрийн салбар хороо хариуцна.

6.4. Бодлогын эхний үе шатны хэрэгжилтийн үр дүнг 2023 оны эхний улиралд багтаан үнэлж, хоёрдугаар үе шатанд авах арга хэмжээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргана.

oooooooooOOoooooooooooooooo